



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 07 сарын 27 өдөр

Дугаар А/264

Мандалговь

Их зохиолч С.Буяннэмэхийн 120 жилийн  
ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дугаар зүйлийн 29.1.5 (а), 30.1.17, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1, 16.1.8, 16.1.12, Дундговь аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1.2.1.4, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.3.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлгэрхангай сумын харьяат Монгол Улсын Алдарт Гавьяат уран зохиолч Сономбалжирын Буяннэмэхийн мэндэлсний 120 жилийн ой 2022 онд тохиохтой холбогдуулан, түүний хөдөлмөр бүтээлийг олон нийтэд сурталчлан алдаршуулах ажлыг зохион байгуулсугай.

2. Их зохиолч С.Буяннэмэхийн 120 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч:

Л.Доржбат(Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

А.Нарантуяа(Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

М.Болор-Эрдэнэ(Нийгмийн бодлогын хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Х.Цогзолмаа(Боловсрол, соёл урлагийн газрын ахлах мэргэжилтэн)

С.Намжилмаа(Боловсрол, соёл урлагийн газрын мэргэжилтэн)

С.Бат-Оргил(Сайнцагаан сумын Засаг дарга)

М.Батсүх(Дэлгэрхангай сумын Засаг дарга)

До.Цэнджав(Монголын зохиолчдын эвлэлийн Удирдах зөвлөлийн дарга)

Д.Доржсүрэн(Төв Халхын дуулалт жүжгийн театрын дарга)

А.Ууганбаяр("Тэнгэрийн тэмдэг" хүүхдийн театрын дарга)

М.Бямбажав(Музейн захирал)

Ж.Мөнхтөр(Аймгийн Утга зохиолын нэгдлийн тэргүүн)

Л.Амаржаргал ("Төгөлдөр Буяннэмэх" ТББ-ын тэргүүн)

481210907

С.Пүрэвсүрэн("Дундговийн амьдрал" сонины эрхлэгч)

Г.Түвшинтөр("Дундговь урлаг сан"-гийн тэргүүн)

А.Нансалмаа(Аймгийн Төв Номын сангийн захирал)

Нарийн бичгийн дарга:

3. Дээрх ойг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөө гарган, үр дүнтэй хэрэгжүүлж ажиллахыг ажлын хэсэг (Л.Доржбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ц.МӨНХБАТ.

